

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

### СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН ТӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭГ ОРЛУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 20<sup>1</sup> дүгээр зүйлийн 20<sup>1.6</sup> дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт байрлах MV-018915 дугаартай "Дулаан-Уул", MV-018916 дугаартай "Зөөвч-Овоо", MV-018914 дугаартай "Өмнөт" цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Бадрах Энержи" ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулахаар тус тус тогтсугай.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг хавсралтаар тогтоосугай.

3.Энэ тогтоолыг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

Монгол Улсын Их Хурлын 2024 оны  
... дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ  
ТУСГАЙ ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ**

| Ураны хүдрийн баяжмал<br>(ураны исэл U3O8)-ын зах зээлийн үнэ<br>(ам.доллар/фунт) | Ашигт малтмалын нөөц ашигласны<br>тусгай төлбөрийн хувь, хэмжээ |
|-----------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|
| 0-40 хүртэл                                                                       | 0.0%                                                            |
| 40-50 хүртэл                                                                      | 0.5%                                                            |
| 50-аас дээш                                                                       | 5.0%                                                            |

**БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН  
ТЭРГҮҮН ШАДАР САЙД  
БӨГӨӨД ЭДИЙН  
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН  
САЙД**

**БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН  
САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА**

**БАТЛАВ.  
САНГИЙН САЙД**

**БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Л.ГАНТӨМӨР**

**Н.УЧРАЛ**

**Б.ЖАВХЛАН**

**О.АЛТАНГЭРЭЛ**

## **СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН ТӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭГ ОРЛУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Цөмийн энергийн тухай хуульд орсон 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөд “5.5.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.” гэж, мөн “20<sup>1</sup>.5.Энэ хуулийн 5.5-д заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг энэ хуулийн 5.2, 5.3-т зааснаас өөрөөр тогтоосон бол төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно.” гэж, мөн “20<sup>1</sup>.6.Энэ хуулийн 20<sup>1</sup>.5-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэж тус тус заасан.

Энэ нь цацраг идэвхт ашигт малтмалыг хөрөнгө оруулагч талтай хамтран ашиглахдаа зөвхөн хувьцаа эзэмших замаар бус Монгол Улсын Үндсэн хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх зарчмыг бусад хэлбэрээр хангуулах боломжийг бүрдүүлсэн байна.

### **1.2.Практик шаардлага**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн нэг нь тус хөтөлбөрийн 3.3.1.11-д “Зөөвч-Овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулна.” гэж заасан Монгол, Францын хамтарсан Ураны төсөл юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар болон

Орано Майнинг САС хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн хэлэлцээний протоколд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр талууд гарын үсэг зурсан.

“Зөөвч-Овоо” төслийг хэрэгжүүлэх хугацаанд “Бадрах энерги” ХХК-ийн 34 хувийн энгийн хувьцааны ногдол ашигт 2,151 сая ам.доллар, АМНАТ-д 717 сая ам.доллар буюу нийт улс, орон нутгийн төсөвт 5.6 тэрбум ам.доллар төвлөрөх тооцоолол гарсан. Харин 34 хувийн энгийн хувьцааг тус хэлэлцээний протоколын дагуу 10 хувийн давуу эрхийн хувьцаа, 5 хувийн тусгай АМНАТ-аар орлуулж, 14 хүртэлх хувийн суурь болон өсөн нэмэгдэх АМНАТ тооцоход давуу эрхийн хувьцаанд 593 сая ам.долларын ногдол ашиг, АМНАТ-д 2,007 сая ам.доллар (суурь АМНАТ-д 717 сая ам.доллар, тусгай АМНАТ-д 717 сая ам.доллар, өсөн нэмэгдэх АМНАТ-д 573 сая ам.доллар), нийт улс орон нутгийн төсөвт 5.2 тэрбум ам.доллар төвлөрөхөөр байна.

Хэдийгээр 34% энгийн хувьцааны хувилбарын тооцоолол нь илүү санхүүгийн өгөөжтэй мэт боловч дараах үндэслэлээр протоколд 34 хувийн энгийн хувьцааг

1.Засгийн газар тодорхой хэмжээ (34 ба түүнээс дээш)-ний хувьцаа эзэмших тохиолдолд төслийн хэрэгжилтийн явцад Засгийн газар анх тооцож байсан ногдол ашгаа хүртэж чадахгүй байх нөхцөл байдал үүсэж, төслийн өгөөж тодорхойгүй хугацаагаар хойшлох эрсдэл дэлхийн бусад улс орнуудад түгээмэл байна<sup>1</sup>.

Учир нь хөрөнгө оруулагч зардлыг удирдах, төслийг зээлээр санхүүжүүлэх зэрэг олон хэлбэрээр төслийн төлөх татвар хураамжийг бууруулах боломжтой байдаг.

Дэлхийн банкны зүгээс хийсэн судалгаандаа Монгол Улсын Засгийн газрыг дараа дараагийн төслүүдээ хөдөлгөхдөө жижиг хувьцаа эзэмшигчээр оролцохоос зайлсхийж, төсөлд бүтээгдэхүүн хуваах гэрээ, эсхүл АМНАТ-өөр оролцохыг зөвлөмж болгосон байна<sup>2</sup>.

2.Төслөөс улс, орон нутгийн төсөвт төвлөрөх татвар, төлбөр, хураамжийн орлого нь ногдол ашгийн орлоготой харьцуулбал төслийн зардлын өсөлтөд сул мэдрэг буюу эрсдэлгүй орлогод тооцогддог.

Өөрөөр хэлбэл, Засгийн газар 34%-ийн энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Монголын талд ногдох нийт 5.6 тэрбум ам.долларын орлогын 82% нь зардлын өсөлтөд өртөмтгий буюу эрсдэлтэй орлого, үлдсэн 18% нь зардлын өсөлтөөс үл хамаарах эрсдэлгүй, найдвартай орлого байна.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар уг хувилбараар төсөлд оролцвол хөрөнгө оруулагч төслийн хугацаанд төслийг зээлээр санхүүжүүлэх, зардлын удирдах зэрэг төрөл бүрийн хэлбэрээр Монголын талд ногдох татвар хураамж, ногдол ашгийг бууруулах эрсдэлтэй юм.

Засгийн газар нь 10 хувийн давуу эрхийн хувьцаа, АМНАТ-аар орлуулснаар эрсдэлгүй орлогын хувийг 18%-аас 45% хүртэл өсгөх бөгөөд нэмэлтээр төслийг зээлээр санхүүжүүлэхэд тодорхой хязгаар тавихаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцэн ойлголцсон.

---

<sup>1</sup>The Role of the State in Mongolia's Mining Sector, 2021, World bank.

<sup>2</sup>The Role of the State in Mongolia's Mining Sector, 2021, World bank.

Энэ нөхцөлд Монгол Улсын Засгийн газар ногдол ашиг хуваарилах хугацааг хүлээлгүйгээр төсөл хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн 19 хүртэлх хувийн АМНАТ-ийг тооцож, үр өгөөжөө хүртэх шууд боломж бүрдэхээр байна.

Иймд 34 хувийн энгийн хувьцааг 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа, 5 хувийн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж, ногдол ашиг хуваарилах хугацааг хүлээлгүйгээр төслийн үр өгөөжийг шууд хүртэх зорилгоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

Дээрх хувилбарыг сонгосноор төслийн үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох тооцоолол гарсан бөгөөд үүнийг хөрөнгө оруулагчтай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд баталгаажуулан тусгахаар талууд тохиролцсон болно.

### **Хоёр.Тогтоолын төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Тогтоолын төсөлд дээр дурдсан хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн олон улсын сайн туршлагыг харгалзан Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт байрлах MV-018915 дугаартай "Дулаан-Уул", MV-018916 дугаартай "Зөөвч-Овоо", MV-018914 дугаартай "Өмнөт" цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Бадрах Энержи" ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг Монгол Улсад эдийн засгийн үр ашигтай байх хувилбарыг харгалзан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулах асуудлыг тусгана.

Тогтоолын төсөл нь 3 заалттай байх бөгөөд 1 дүгээр заалтаар төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулах асуудлыг, 2 дугаар заалтаар ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг ураны зах зээлийн үнийн түвшнээс хамаарч тооцон тогтоох зохицуулалтыг, 3 дугаар заалтаар тус тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тогтооно.

**Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Тогтоолын төсөл батлагдсанаар "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.3.1.11-д заасан Зөөвч-Овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулагдаж, Монгол, Францын хамтарсан ураны төсөл үр ашигтай хэрэгжих боломж бүрдэнэ.

Түүнчлэн, төслийн хүрээнд 34 хувийн энгийн хувьцааг хэлэлцээний протоколын дагуу 10 хувийн давуу эрхийн хувьцаа, 5 хувийн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж, 9 хүртэлх хувийн өсөн нэмэгдэх АМНАТ тооцож авах тохиолдолд давуу эрхийн хувьцаанд 593 сая ам.долларын ногдол ашиг, АМНАТ-д 2,007 сая ам.доллар нийт улс орон нутгийн төсөвт 5.1 тэрбум ам.доллар төвлөрөх боломжтой болно.

Мөн Монгол Улсын Засгийн газар ногдол ашиг хуваарилах хугацааг хүлээлгүйгээр төсөл хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн 19 хүртэлх хувийн АМНАТ-ийг тооцож, үр өгөөжөө хүртэх шууд боломжтой болно.

**Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг**

**хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон Улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 35, 36 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулна.

---oOo---

## ТАНИЛЦУУЛГА

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Цөмийн энергийн тухай хуульд орсон 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөд “5.5.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах, бүтээгдэхүүн хуваах, төрийн эзэмшлийн хувьцааны төрлийг өөрчлөх, эдгээрийг хослуулах зэрэг үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал өөрөөр тогтоож болно.” гэж, мөн “20<sup>1</sup>.5.Энэ хуулийн 5.5-д заасны дагуу цацраг идэвхт ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг энэ хуулийн 5.2, 5.3-т зааснаас өөрөөр тогтоосон бол төрийн эзэмшлийн хувь, хэмжээг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно.” гэж, мөн “20<sup>1</sup>.6.Энэ хуулийн 20<sup>1</sup>.5-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, цацраг идэвхт ашигт малтмалын зах зээлийн үнийн түвшнийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэж тус тус заасан.

Энэ нь цацраг идэвхт ашигт малтмалыг хөрөнгө оруулагч талтай хамтран ашиглахдаа зөвхөн хувьцаа эзэмших замаар бус Монгол Улсын Үндсэн хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх зарчмыг бусад хэлбэрээр хангуулах боломжийг бүрдүүлсэн байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан 14 мега төслийн нэг болох Монгол, Францын хамтарсан ураны төслийн үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох хувилбарыг судалж, тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн төрийн эзэмшлийн хувь, хэмжээг 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа, ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах талаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл бэлтгэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар болон Орано Майнинг САС хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийн хэлэлцээний протоколд 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр талууд гарын үсэг зурсан.

“Зөөвч-Овоо” төслийг хэрэгжүүлэх хугацаанд “Бадрах энерги” ХХК-ийн 34 хувийн энгийн хувьцааны ногдол ашигт 2,151 сая ам.доллар, АМНАТ-д 717 сая ам.доллар буюу нийт улс, орон нутгийн төсөвт 5.6 тэрбум ам.доллар төвлөрөх тооцоолол гарсан. Харин 34 хувийн энгийн хувьцааг тус хэлэлцээний протоколын дагуу 10 хувийн давуу эрхийн хувьцаа, 5 хувийн тусгай АМНАТ-аар орлуулж, 14 хүртэлх хувийн суурь болон өсөн нэмэгдэх АМНАТ тооцоход давуу эрхийн хувьцаанд 593 сая ам.долларын ногдол ашиг, АМНАТ-д 2,007 сая ам.доллар (суурь АМНАТ-д 717 сая ам.доллар, тусгай АМНАТ-д 717 сая ам.доллар, өсөн нэмэгдэх АМНАТ-д 573 сая ам.доллар), нийт улс орон нутгийн төсөвт 5.2 тэрбум ам.доллар төвлөрөхөөр байна.

Хэдийгээр 34% энгийн хувьцааны хувилбарын тооцоолол нь илүү санхүүгийн өгөөжтэй мэт боловч Засгийн газар 34 хувийн хувьцаа эзэмших нөхцөлд төслийн хэрэгжилтийн явцад хөрөнгө оруулагч зардлыг удирдах, төслийг зээлээр санхүүжүүлэх зэрэг олон хэлбэрээр төслийн төлөх татвар хураамжийг бууруулах боломжтой байдаг тул Засгийн газар анх тооцож байсан ногдол ашгаа хүртэж чадахгүй, төслийн өгөөж тодорхойгүй хугацаагаар хойшлох эрсдэл байна. Дэлхийн банкны зүгээс хийсэн судалгаандаа Монгол Улсын Засгийн газрыг дараа дараагийн төслүүдээ хөдөлгөхдөө жижиг хувьцаа эзэмшигчээр оролцохоос зайлсхийж, төсөлд бүтээгдэхүүн хуваах гэрээ, эсхүл АМНАТ-өөр оролцохыг зөвлөмж болгосон байгааг<sup>3</sup> харгалзах нь зүйтэй.

Түүнчлэн төслөөс улс, орон нутгийн төсөвт төвлөрөх татвар, төлбөр, хураамжийн орлого нь ногдол ашгийн орлоготой харьцуулбал төслийн зардлын өсөлтөд сул мэдрэг буюу эрсдэлгүй орлогод тооцогддог. Өөрөөр хэлбэл, Засгийн газар 34%-ийн энгийн хувьцаа эзэмших тохиолдолд Монголын талд ногдох нийт 5.6 тэрбум ам.долларын орлогын 82% нь зардлын өсөлтөд өртөмтгий буюу эрсдэлтэй орлого, үлдсэн 18% нь зардлын өсөлтөөс үл хамаарах эрсдэлгүй, найдвартай орлого байна.

Харин Засгийн газар нь 10 хувийн давуу эрхийн хувьцаа, АМНАТ-аар орлуулснаар эрсдэлгүй орлогын хувийг 18%-аас 45% хүртэл өсгөх боломжтой болох юм.

Иймд 34 хувийн энгийн хувьцааг 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа, 5 хувийн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж, Монгол Улсын Засгийн газар ногдол ашиг хуваарилах хугацааг хүлээлгүйгээр төсөл хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн төслийн үр өгөөжийг шууд хүртэх боломжийн бүрдүүлэх зорилгоор тогтоолын төслийг боловсрууллаа.

Дээрх хувилбарыг сонгосноор төслийн үр өгөөжийн дийлэнх нь Монгол Улсад ногдох тооцоолол гарсан бөгөөд үүнийг хөрөнгө оруулагчтай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд баталгаажуулан тусгахаар талууд тохиролцсон болно.

Тогтоолын төслийн 1 дүгээр заалтад “Бадрах Энержи” ХХК-ийн төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулах асуудлыг, 2 дугаар заалтад ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тогтоох, 3 дугаар заалтад тус тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгасан болно.

Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг ураны зах зээлийн үнийн түвшнээс хамаарч дараах байдлаар тогтоохоор заасан.

| Ураны хүдрийн баяжмал<br>(ураны исэл U3O8)-ын зах зээлийн үнэ<br>(ам.доллар/фунт) | Ашигт малтмалын нөөц ашигласны<br>тусгай төлбөрийн хувь, хэмжээ |
|-----------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|
| 0-40 хүртэл                                                                       | 0.0%                                                            |
| 40-50 хүртэл                                                                      | 0.5%                                                            |
| 50-аас дээш                                                                       | 5.0%                                                            |

<sup>3</sup>The Role of the State in Mongolia's Mining Sector, 2021, World bank.



Тус тогтоолын төсөл батлагдсанаар “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.11-д заасан Зөөвч-Овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулагдаж, Монгол, Францын хамтарсан Ураны төсөл үр ашигтай хэрэгжих боломж бүрдэнэ.

Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хавсаргав.

---oOo---

## Улс орнуудын цацраг идэвхт ашигт малтмалын салбарт ногдуулах татварын хэмжээ

| № | Улс орнууд,<br>нөөц                                 | Уран<br>олборлолт,<br>тонн /2022 оны<br>байдлаар/ | ААНОАТ                                                                           | АМНАТ, %                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Өсөн нэмэгдэх<br>АМНАТ, %                                                                                                                                                                                                                                                        | Хууль,<br>ТОГТООМЖ                                                                                                          |
|---|-----------------------------------------------------|---------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Казахстан<br>815,200 тн,<br>нийт<br>нөөцийн<br>13%  | 21,227<br>21,100 тн /2023<br>оны байдлаар/        | 20%                                                                              | 2023.01.01-ээс эхлэн 6%-иар тогтоосон.<br>2025.01.01-ээс эхлэн зөвхөн 2025 онд<br>холбогдох хувь хэмжээ 9% хүртэл<br>нэмэгдэнэ.<br>2026 оноос хойш төлөх татварын хувь<br>хэмжээ олборлосон дүнгээс хамаарна.<br>500 тн – 4%<br>1000 тн – 6%<br>2000 тн – 9%<br>3000 тн – 12%<br>4000 тн – 15%<br>4000-аас дээш – 18% байхаар<br>Ерөнхийлөгчийн зарлиг гарсан. | Тайлант хугацаанд<br>U <sub>3</sub> O <sub>8</sub> -ийн үнэ<br>тодорхой босго<br>хэмжээнээс<br>хэтэрсэн<br>тохиолдолд 2026<br>оноос хойш<br>татварын хувь<br>хэмжээ нэмэгдэнэ.<br>70\$/фунт – 0.5%<br>80\$/фунт – 1%<br>90\$/фунт – 1.5%<br>100\$/фунт – 2%<br>110\$/фунт – 2.5% | Газрын баялаг<br>ашиглах тухай<br>хууль,<br>Татварын тухай<br>хууль                                                         |
| 2 | Канад<br>588,500 тн,<br>нийт<br>нөөцийн<br>10%      | 7,351                                             | Улсын төсөвт -15%,<br>орон нутгийн төсөвт<br>8-16%                               | Үндсэн металл, алмаз, уран зэрэг<br>металл ашигт малтмал – Төлбөр<br>төлөхөөс өмнөх уурхайн нийт орлогын<br>1%, Төлбөр төлсний дараах уурхайн<br>нийт орлогын 1%, цэвэр орлогын 12%<br>байна.                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                  | Эрдэс<br>баялагийн<br>татварын тухай<br>хууль (1983),<br>Орон нутгийн<br>хууль болон<br>борлуулалтын<br>ашгаас<br>хамаарна. |
| 3 | Австрали<br>1,684,100 тн,<br>нийт<br>нөөцийн<br>28% | 4,553                                             | 30%<br>(Эргэлтийн хөрөнгө<br>нь 50 сая австрали<br>доллараас доош<br>бол 25%-ийн | Уран - 3.75%<br><br>Ашигт малтмалын нөөц ашиглах 5.5 %<br>7.5% Буталсан бүтээгдэхүүн бол<br>5% Баяжмалд                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                  | Татварын тухай<br>хууль (Ашигт<br>малтмалын<br>нөөц<br>ашигласны<br>татвар), Уул                                            |

|   |                                          |       |                                                                                                                                                                         |                                                                                                                          |                                                                                                   |                                                                                                  |
|---|------------------------------------------|-------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------|
|   |                                          |       | татварын хөнгөлөлттэй)                                                                                                                                                  | 2.5% металл, түүнтэй төстэй бүтээгдэхүүнд, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд тонн тутамд тогтоосон үнээр тооцдог. |                                                                                                   | уурхайн дүрэм, журам (1981)                                                                      |
| 4 | Нигер<br>311,100 тн,<br>нийт нөөцийн 5%, | 2,020 | 30% (25 сая нигерийн нариагийн орлоготой бол ААНОАТ-0%, 25-100 сая нигерийн нариа бол ААНОАТ-20%, түүнээс дээш бол том аж ахуй нэгж гэж үзэн 30%-ийн ААНОАТ ногдуулдаг) | Уран - 5,5%<br><br>(Борлуулалтын ашгаас хамаарч 12-15% болгохоор ажиллаж байна.)                                         | Үнэд суурилсан нөөц ашигласны 0-10%-ийн төлбөрийг Нигерийн Хөрөнгө оруулалтын газарт төлөх ёстой. | Уул уурхайн тухай хууль (2006), борлуулалтын ашгаас хамаарч нэмэгдэнэ.                           |
| 5 | Намиби<br>470,100 тн,<br>нийт нөөцийн 8% | 5,613 | Уул уурхайн компани болон уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг компани 2024-2025 онд ногдох ААНОАТ-37.5% (Алмазанд 55%)                                                   | Уран - 3%,<br>борлуулалтын орлогоос хамааран өснө.                                                                       |                                                                                                   | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 1981 онд батлагдсан Эрдэс баялгийн хуулиар зохицуулдаг. |
| 6 | ОХУ<br>480,900 тн,<br>нийт нөөцийн 8%    | 2,508 | 20% (Улсын төсөвт 2%, орон нутгийн төсөвт 18%)                                                                                                                          | /Зэс-8%<br>Алт-6%<br>Төмөр -4,8%/                                                                                        |                                                                                                   | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, татварын тухай дүрэм, журам                               |

|    |                                                    |       |                                                                                                                                                                                                                      |                                                                                            |  |                                                                                                                      |
|----|----------------------------------------------------|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------|--|----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 7  | Узбекистан<br>131,300 тн,<br>нийт<br>нөөцийн<br>2% | 3,300 | 15% (ААНОАТ-ийн хувь хэмжээг Татварын тухай хуульд өмнө жил нь ерөнхийлөгчийн зарлигаар тогтоодог)                                                                                                                   | Уран-8%<br><i>/Байгалийн хий -10%,<br/>Алт-7%<br/>Зэс-7%<br/>Карбид-2.7%<br/>Нүүрс-4%/</i> |  | 2019.12.30-ны өдрөөс эхлэн мөрдөгдөж буй Татварын тухай хуулиар зохицуулагддаг. 2022.01.01-ээс эхлэн өөрчлөлт орсон. |
| 8  | БНХАУ<br>223,900<br>нийт<br>нөөцийн<br>4%          | 1,700 | 25% (ААНОАТ-ийн тухай хуулийн дагуу стандарт татварын хувь хэмжээ)                                                                                                                                                   | 3%                                                                                         |  | Татварын тухай хууль                                                                                                 |
| 9  | АНУ<br>59,400<br>нийт<br>нөөцийн<br>1%             | 75    | 21% (2017.12.22-нд батлагдсан АНУ-ын татварын шинэчлэгдсэн хуулиар “дэлхий даяарх- татварын тогтолцооноос “нутаг дэвсгэр”-ийн татварын тогтолцоонд шилжиж, ААНОАТ-ын 35% хувь хэмжээг тогтмол 21% болгон бууруулсан) | Уран – Шинэ уурхай 4%, үйл ажиллагаагаа явуулж буй уурхай 8%                               |  | Уул уурхайн хууль, 1872 он                                                                                           |
| 10 | Украин<br>107,200<br>нийт<br>нөөцийн 2%            | 100   | 18% (ААНОАТ-ын стандарт 18%, 2024 оноос эхлэн банкуудын ААНОАТ-ийн хэмжээг 25%                                                                                                                                       | Уран - 5%                                                                                  |  | Уул уурхайн хууль 2017 он                                                                                            |

|    |                                                        |     | хүртэл<br>нэмэгдүүлсэн )                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                            |                           |                                                                     |                                                    |
|----|--------------------------------------------------------|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|---------------------------------------------------------------------|----------------------------------------------------|
| 11 | Өмнөд<br>Африк<br><br>320,900<br>нийт<br>нөөцийн<br>5% | 200 | 27%<br>(2023.03.31-ээс<br>өмнө дуусгавар<br>болох татварын<br>жилүүдэд ААНОАТ-<br>28, 2023.03.31-нээс<br>хойш дуусгавар<br>болох татварын<br>жилүүдэд 27%<br>болсон.<br>Алт олборлож буй<br>компаниудад<br>татварын тусгай<br>хувь хэмжээг<br>тогтоодог бол бусад<br>ашигт малтамлд<br>жирийн ААН-д<br>ногдуулдаг татварыг<br>ногдуулдаг) | Уран – Эхний 5 жилд 2%, үүний дараа<br>5%<br><br>(Боловсруулсан ашигт малтмалын<br>АМНАТ 0.5-5%,<br>Боловсруулаагүй ашигт малтмалын<br>АМНАТ 0.5-7%)                                       |                           | Уул уурхайн<br>хууль 1971 он,<br>Уул уурхайн<br>дүрэм журам<br>2011 |                                                    |
| 12 | БНЭУ<br><br>292,867 тн                                 | 600 | 41.60-43.68%<br>(Хуульд заасан<br>гадны хөрөнгө<br>оруулалттай ААН-<br>ын суурь ААНОАТ-<br>40%, мөн 4%<br>хүртэлх эрүүл мэнд,<br>боловсролын<br>татварыг нэмдэг )                                                                                                                                                                         | Уран-6.6%<br><br>(2021 онд АМНАТ-ийг эхний 4 жилд<br>дотоодын борлуулалтын 4%, экспортын<br>7%, дараагийн 3 жилд дотоодын<br>борлуулалтын 3%, экспортын 6% байх<br>ёстой гэж зохицуулсан.) | (үнэ<br>нэмэгдсэн<br>10%) | өсөхөд<br>үнийн                                                     | Ашигт<br>малтмал, уул<br>уурхайн хууль,<br>1957 он |
| 13 | БНЧУ<br><br>119,107 тн                                 | 193 | 21%<br>(2024 оноос эхлэн<br>ААНОАТ-21%<br>болсон. Бүх ААН-д                                                                                                                                                                                                                                                                               | Уран – 0.3%<br><br>(АМНАТ-ын 25%-ийг улсын төсөвт,<br>75%-ийг орон нутгийн төсөвт<br>төвлөрүүлдэг.)                                                                                        |                           | Уул уурхайн<br>хууль, 1988 он                                       |                                                    |

|    |                                   |    |                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                           |  |                                                           |
|----|-----------------------------------|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------|--|-----------------------------------------------------------|
|    |                                   |    | хамаарна. 2024 өмнөх нь 19%)                                                                                                                                                                                                                         |                                                                                                           |  | 2006 онд шинэчлэгдсэн                                     |
| 14 | Румын                             | 50 | 16%<br>Жижиг компани 60 мян.евро хүртэл-1%,<br>60 мян.еврогоос дээш-3%                                                                                                                                                                               | Уран - 5%<br><br>(Нийт үйлдвэрлэлийн үнийн дүнгийн 5%)                                                    |  | Эрдэс баялгын нөөцийн үндэсний агентлаг                   |
| 15 | Пакистан                          | 45 | 29%<br>Жижиг компани 20% (Мөн нийт орлогын хэмжээнээс хамаарч супер татвар нэмж ногдуулдаг. Үүнд: (Пакистан рупи) 150-200 сая - 1%, 200-250 сая – 2%, 250-300 сая – 3%, 300-350 сая – 4%, 350-400 сая – 6%, 450-500 сая – 8%, 500 саяас дээш – 10%). | Хөрөнгө оруулалт татаж байгаа тохиолдолд эхний 5 жилд АМНАТ-6.5%, 5 жилийн дараагаас аажмаар нэмэгдүүлнэ. |  | Татварын тухай хууль, Төлбөр хураамж, гаалийн тухай хууль |
| 16 | Бразил<br>276,800 нийт нөөцийн 5% | 43 | 15%<br>ААН-ийн орлого жилд 240,000 бразил реалаас давсан бол 10%-ийн татвар нэмж ногдуулдаг.                                                                                                                                                         | Ашигт малтмал 1 – 3.5%                                                                                    |  | Уул уурхайн тухай хууль (1967)                            |
| 17 | Иран                              | 20 | 22.5%<br>(ААНОАТ-ын стандарт хувь хэмжээ 25%)                                                                                                                                                                                                        |                                                                                                           |  |                                                           |

|               |                     |   |                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                       |  |                                                                                                                             |
|---------------|---------------------|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 18            | Малави<br>16,272 тн | 0 | 35%<br>(Уул уурхайн төслөөс хүү, роялти, ногдол ашиг зэргээс олсон орлогын 10%-аар нэмж татвар төлнө)                                                                                                       | Уран – 5%<br><br>(Австралийн Лотус компанитай 2024.08 сард байгуулсан улс ураны уурхай хөгжүүлэх гэрээнд Малави улс АМНАТ-5%, ААНОАТ-ыг 30% байхаар тогтоосон байна.) |  | Татварын тухай хууль                                                                                                        |
| 19            | ХБНГУ               | 0 | 30 – 33%<br>(АМНАТ болон ногдол ашигийг эх үүсвэрээс нь суутган авч татвар ногдуулдаг. Корпорацийн татвар 15%+5.5%, худалдааны татвар 8.75 – 20.3% гэсэн 2 татвар ногдуулдаг. Хотуудаас шалтгаалан өөр өөр) | Ашигт малтмал – 0-40%<br><br>(Уурхайн талбайн км.квадрат тутамд 5 евро)                                                                                               |  | Холбооны уул уурхайн хууль                                                                                                  |
| 20            | БНФУ                | 0 | 2020.01.01-ээс 31%,<br>2021.01.01-ээс 27.5%,<br>2022.01.01-ээс 25%                                                                                                                                          | Ашигт малтмал - 33%                                                                                                                                                   |  | Татварын тухай хууль (7.63 сая еврогоос доош эргэлтийн хөрөнгөтэй бол эхний 38000 еврод 15%-ийн татварын хөнгөлөлт үзүүлнэ. |
| Дундаж хэмжээ |                     |   | 27%                                                                                                                                                                                                         | 5%                                                                                                                                                                    |  |                                                                                                                             |

|    |                                                |        |               |                                                  |  |                                    |
|----|------------------------------------------------|--------|---------------|--------------------------------------------------|--|------------------------------------|
| 21 | Монгол<br>192.241 тн<br>Нийт<br>нөөцийн 2%     |        | 10% эсвэл 25% | Нүүрс – 2.5%<br>Алтнаас бусад – 5% /доод хэмжээ/ |  | Ашигт<br>малтмалын<br>тухай хууль. |
|    | Нийт                                           | 49,355 |               |                                                  |  |                                    |
|    | Ураны исэл<br>(U <sub>3</sub> O <sub>8</sub> ) | 58,201 |               |                                                  |  |                                    |

Эх сурвалж: <https://taxsummaries.pwc.com/france/corporate/taxes-on-corporate-inco>